



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 4-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-9

1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	4-9
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 38 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Лүндэг, Ц.Мөнхбат;
Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Н.Наранбаатар,
Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Г.Очирбат.

Нэг. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Гэр бүлийн бодлогын газрын Хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн яамны Гэр бүлийн бодлогын газрын Хэлтсийн дарга А.Хишигбаяр нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан

Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийн төслийг соёрхон батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Жаргалан нарыг дэмжсэнээр тооцож, 72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 15 цаг 38 минут

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцэд байгаа гишүүдийн мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажыкберийн Жангаабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа. Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай Засгийн газар 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Хоёр улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын сайд Тилеуханы Аубакир танилцуулна аа. Аубакир сайдын микрофонд урьж байна.

Т.Аубакир: Монгол УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж 2 улсын иргэдийн нийгмийн харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэний нэгэн адилаар тэтгэвэр, тэтгэмж авах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж ирлээ.

Одоогийн байдлаар ОХУ, БНСУ, Унгар Улс, БНПУ, БНТУ, БНЧУ-тай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулж шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох шимтгэл төлсөн хугацаанд ноогдох тэтгэвэр тогтоолгон авах, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцсон хэлэлцээрийг хэрэгжүүлж байна аа.

Түүнчлэн БНКАУ, Бүгд Найрамдах Австри Улс, Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр шинээр байгуулах, ОХУ-тай байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж байна аа. Энэ хүрээнд БНКАУ-тай 2018 оноос Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, 2 улсын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар талууд хэлэлцээрт 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуулиудад зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм аа.

Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хууль батлагдаж хэрэгжсэнээр 2 улсын иргэд Монгол Улс болон БНКАУ-д ажилласан шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн тооцуулж өндөр настны тэтгэвэр тогтоолгох мөн Монгол Улсын иргэд БНКАУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдэж нийгмийн хамгааллын баталгаа нь сайжрах юм аа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдахгүй юм аа. Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд Засгийн газраас уг асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Ванчингийн Рэнцэнханд, НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Цэнд-Аюушийн Ганцэцэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэлтсийн дарга Амарсайханы Хишигбаяр, тус яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Бямбаагийн Мөнхбаяр гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байна аа.

Оруулж ирсэн хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Анар гишүүн дарсан уу, үгүй юу. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ хэлэлцээр, гэрээг дэмжиж байгаа. Монгол Улс нийгмийн хамгааллын чиглэлээр 7 дахь улстайгаа ингээд гэрээ байгуулах гэж байгаа юм байна. Цаашдаа бусад улсуудад Монгол Улсын иргэдийн ажиллаж байгаа

улсуудтай ийм чиглэлийн гэрээ хэлэлцээр хийх ажлууд хэр хийгдэж байгаа вэ? Хөдөлмөрийн яам. Энийг тодруулж асууя 1 дүгээрт.

Хоёрдугаарт, Монгол Улсад өөрсдөө энэ ажиллах хүчний асуудал дээр нэлээн янз бүрийн маргаантай сэдвүүд явдаг. Ялангуяа ажил олгогчдын дунд ажиллах хүчний хомсдолд орчихлоо. Тогтвортой чадвартай ажиллах хүчний бодит хомсдол бий болчихсон. Үүнийг шийдвэрлэх шаардлага байна аа гэдгийг их ярьж байгаа. Энэ дээр Хөдөлмөрийн яам өөрөө ямар бодлого барьж байгаа вэ? Монгол Улсад ажилласан гадаад улсын иргэдийг үүнтэй адилхнаар дүйцүүлдэг хэлэлцээр эрх зүйн актууд бий юу? Энэ ямар улсууд дээр байна вэ? Энэ дээр тодорхой судалгаа юу байна аа? Тодруулаад хэлбэл энэ Казахстан улстай хийж байгаа энэ хэлэлцээр гэрээнд ямар ямар давуу талууд бий болж байгаа вэ? Өөрөөр хэлэх юм Казахстан улсад ажиллаж амьдарч байсан иргэд мөн Монгол Улсад ажиллаж амьдарч байсан иргэдийн хооронд энэ гэрээ хэлэлцээр байгуулснаар ямар сайн давуу нөхцөлүүд бий болж байгаа гэдгийг тодруулж хэлж өгөөч ээ гэж асууж байна аа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Яамнаас ажлын хэсгээс 6 номер албан тушаал, нэрээ танилцуулаад асуултад хариулаарай. 6 номер.

В.Рэнцэнханд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Рэнцэнханд байна аа. Монгол Улс одоогийн байдлаар ОХУ, БНАУ Австрали улсуудтай бол хэлэлцээр үе шатад явж байна. Тухайлбал Австрали улстай бол энэ хавар хэлэлцээрийг бол соёрхон батлаад зурсан байгаа Австри улстай. Австрали улс бол хэлэлцээрийн үе шатад явж байгаа бөгөөд ирэх 7 хоногт ирж биечлэн хэлэлцээр бол хийгдэхээр байгаа. ОХУ-ын хэлэлцээрийг бол эхний ээлжид бол 2 талаасаа тохиролцчихсон одоо Засгийн газрын хуралдаанд оруулахад бэлдээд яамдуудаас санал авах үе шатад явж байна аа.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулт өгье. Аубакир сайд.

Т.Аубакир: Батсүмбэрэл гишүүний асуултад товчхон хариулъя.

Монгол Улсад гадаадын ажиллах хүчийг ажиллуулах талаар яг өнөөдөр гадаадын харьяат мөн манай Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар гээд Хууль зүйн яам болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажлын хэсэг гарч ажиллахаар болж байгаа. Сүүлийн үед энэ хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтийн харьцаа хийсэн судалгаанууд байдаг. Яг одоо хөдөлмөрийн насанд хүрсэн иргэдийн маань хэдэн хувь нь яг ажлын байран дээр тогтвортой ажиллаж байгаа. Ажлын байрууд нь юу байна? Шинээр энэ эдийн засаг өсөж байгаатай холбоотой хүн ам өсөж байгаатай холбоотой шинээр бий болох ажлын байруудад бид нар яаж ажиллах хүчээ бэлтгэх ёстой юм. Энэ дээр бид нар гаднын ажиллах туршлага мөн гаднын ажиллах хүчийг Монгол Улсад орж ирээд виз мэдүүлэхээс эхлээд мөн гаднын ажиллах хүчний төлбөрийн асуудал хүртэл яригддаг. Эдгээр зохицуулалтуудыг илүү ойлгомжтой түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх Монгол Улсад дутагдаж байгаа ажиллах хүчийг яаж нөхөх вэ.

Г.Тэмүүлэн: Аубакир сайд гүйцээж хариулъя.

Тийм учраас энэ асуудал бол яг цаг үеэ олсон ажил. Засгийн газар шинээр байгуулагдаад Ерөнхий сайдын зүгээс өгсөн чиглэл бол энэ ажиллах хүчний эрэлт

нийлүүлэлтийн асуудал их цэгцлээ. Монгол Улсад тэртээ тэргүй ажиллах хүч хийчхэж болох ажлын байрыг гадаадаас ажиллах хүчээр нөхөх байдлаар явмааргүй байна аа. Тэдгээрийн ноу хау илүү чадварыг нь энд нутагшуулж үлдээх тал дээр бодлогоо нэг чигтэй болго гэж үүрэг даалгавар өгсний хүрээнд өнөөдөр ингээд 2 яамнаас хамтарсан ажлын хэсэг гарч ажиллаад, виз мэдүүлэхээс нь авхуулаад бусад бичиг баримтын болоод ямар нэгэн хүнд суртал үүсгэхгүйгээр зохицуулах журам нь энэ сардаа багтаад бид нар цэгцлээд ажиллаад явна аа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Нэгдүгээрт, энэ 3 дугаар асуултад хариулт өгсөнгүй. Өөрөөр хэлэх юм бол энэ гэрээ, хэлэлцээр хийгдсэнээрээ Казахстан улсын иргэдэд Монгол Улсын иргэдэд яг ямар давуу нөхцөл сайн байдал бий болж байгаа вэ?

Хоёр дахь юм нь тэр сая 6 номер дээр хариуллаа шүү дээ. Бид нарт өгсөн материал дээр болохоор ОХУ-тай хэлэлцээр хийчихсэн гээд энэ гэрээ байгуулчихсан гээд байж байдаг. Сая танилцуулахдаа бол энэ чинь хэлэлцээр хийгдэж байгаа шатад явж байгаа гэсэн ярьдаг. Энэ тараасан материал нь үнэн юм уу, микрофон дээр хариулсан нь үнэн юм уу? Энийгээ тодорхой болгож өгөөч.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя 6 номер.

А.Хишигбаяр: Гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэлтсийн дарга Хишигбаяр. ОХУ-тай манай Монгол Улс 1982 онд гэрээ байгуулсан байдаг. Энэ гэрээг өнөөдөр хүртэл бид нар хүчин төгөлдөр мөрдөөд явж байгаа. Тэгээд энэ гэрээгээ хуучин ЗХУ-тай байгуулсан байгаа. Тэгэхээр энэ гэрээ маань нэлээн 1981 оны гэрээ учраас бид нар шинэчлэхээр ажиллаж байгаа. Ер нь бол 2 яамны түвшинд бол ажиллаад дууссан байгаа. Тэгээд яамдуудаасаа саналаа авсан байгаа. Удахгүй засгаараа оруулж ирээд тэгээд дахиад шинэчлээд батлах энэ ажлыг хийгээд явж байгаа. Энэ Казахстаны хэлэлцээр бол ямар ач холбогдолтой гэх юм бол ер нь Монгол Улсын иргэдэд илүү их ач холбогдолтой байгаа.

1994-2018 онд Монгол Улсаас 61 мянган хүн Казахстан улс руу шилжсэн байдаг гэсэн ийм тоон мэдээлэл байдаг. Буцаад Монгол Улсад 1.7 мянган иргэн буцаж ирсэн байдаг гэж.

Г.Тэмүүлэн: Гүйцээж хариулъя 6 номер. Өнөөдөр бол 8 мянган хүн амьдарч байгаа. Тэрний 3 мянга гаран нь бол бас хөдөлмөрийн насны хүн байгаа. Энэ хүмүүст бол энэ хэлэлцээр ашиглагдана, хэрэглэгдэнэ. Яаж хэрэглэгдэх вэ гэхээр 1998 онд Казакстан Улс бол бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжсэн байгаа. 1998 оноос өмнө Казакстанд амьдарч байсан Монголд амьдарч байсан хүмүүс ажилласан жилээ нэгтгэж байгаа тэтгэврийнхээ эрхийг үүсгээд тухайн ажилласан жилдээ ноогдох тэтгэврээ тухайн улсаасаа аваад явна.

Харин 1998 оноос хойш Казахстан Улс бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжсэн учраас 1998 оноос хойш Монгол Улсын хүн ямар нэгэн хүн тэнд шимтгэл төлсөн байвал Казахстан улсаас тэтгэврээр авдаг болох ийм нөхцөл л бүрдэж байгаа. Тэгэхээр манайхан Казахстанас Монгол Улс руугаа тэтгэврээ аваад явна аа гэсэн ийм боломж нөхцөл бүрдэх ийм онцлог хэлэлцээр байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа уг асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Батсүмбэрэл гишүүн. Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

Н.Батсүмбэрэл: Энэ хэлэлцээр чинь хавар орж ирээд буцсан. Тэгээд Казах сайдтай болж байгаад Казахстан Улсын хэлэлцээр батлагдах ёстой байсан юм байна. Аубакир сайдад амжилт хүсье.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төв Ази руу явуулж байгаа бодлого чухал байгаад байгаа. Тэгэхээр энэ бусад Станы орнуудад Монгол Улсын иргэд ажиллаж байгаа байдлыг харгалзаж хэлэлцээрийг цааш нь өргөжүүлээрэй гэж захимаар байна. Сая яамны яриад байгаа тэр ОХУ-ыг ЗХУ байх үед нь байгуулсан тэр гэрээг шинэчлэх ёстой юм байна. Энийгээ бас яам даруй түргэн хийж ажиллаарай. Тэгээд та бүхэнд амжилт хүсье ээ дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулъя.

Томьёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар, БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна аа.

Гишүүд санал хураалтын горимд бэлтгэе. Хуруугаа хийцгээгээрэй. Гишүүд бэлэн бус байна. Санал хураалтын горимд бэлтгээрэй. Батсүмбэрэл гишүүн бэлтгээгүй байх шиг байна. Ганбат гишүүн, Тулга, Хосбаяр гишүүн.

Хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд саналаа өгнө үү.

Санал хураалт.

11 гишүүн зөвшөөрсөн байна.

Болормаа гишүүн, Жаргалан гишүүдийг дэмжсэнээр авъя.

13 гишүүн дэмжсэн байна аа.

Санал хураалтад нийт 18 гишүүн оролцоно.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Уг асуудлын талаарх санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах байгаа. Жангабыл гишүүн танилцуулах уу? Та чуулганд танилцуулах уу?

Ингээд Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жангабыл нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөлөө. Баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

15.58 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА